Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Санхүүгийн тайлангийн аудитын заавар, аргачлалын дагуу аудитыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу чанарын хяналтыг дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Мөнхбаяр хэрэгжүүлж, баталгаажууллаа.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Материаллаг байдлын түвшин

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, хувь хэмжээг 1 хувиар тооцов.

Нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аудитаар санхүүгийн тайланг бүхэлд нь хянах учраас зөвхөн орлого, зардлыг суурь болгон сонгох нь зохимжгүй гэж үзсэнтэй холбоотой.

ТЕЗ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь нийт хөрөнгө 135,802,372.3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 1,358,023.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшнийг хэвээр үлдээв.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэлийн үнэлгээний түвшинтэй холбоотой юм.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ НЭГТГЭХЭД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ, АРГАЧЛАЛ

Дархан сумын ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагын санхүүгийн тайлан, Засгийн газрын шугамаар авч, ашиглаж байгаа хөнгөлөлттэй зээл болон буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн тайланг санхүүгийн нэгтгэсэн тайланд хамааруулна”, 54.3-т “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргана” гэж заасны дагуу сумын орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланг гарган ирүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 71 байгууллага, нэгж байгаагаас бүх байгууллага аудитад хамрагдсан бөгөөд үүнээс 51 байгууллага дүгнэлт гаргуулж, хувийн 9 сургууль, 10 цэцэрлэгийн орон нутгийн төсвөөс авсан татаас болон сумын ерөнхий орлогын данс түүвэрт хамрагдсан байна.

Тус тайланд:

- Орон нутгийн төсвийн шууд захирагчдын 10,
- Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 56,
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн 5 буюу нийт 71 санхүүгийн тайланг нэгтгэжээ.

Аудитад хамрагдсан байгууллагуудын 39.4 хувьд Төрийн аудитын газар, 60.6 хувьд аудитын хуулийн этгээд санхүүгийн тайлангийн аудитыг хийв.

Аудитаар дүгнэлт гаргуулсан бүх байгууллагууд “зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна.

Төрийн аудитын байгууллагаас ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагад санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэр				
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрлэсэн	Итгэл үзүүлсэн	Гэрээгээр хийлгэсэн	Аудитад хамрагдаагүй
1	Төсвийн шууд захирагч	9	1	-	1	-
2	ТЗШ-ийн байгууллага	37	19	-	35	-
3	ОНӨААН	5	-	-	5	-
Дүн		51	20	-	41	-

Санхүүгийн тайланг бэлтгэсэн суурь

ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг нягтлан бодох бүртгэлийн аккрузл суурийг хэрэглэж бэлтгэсэн байна.

Тайланг илэрхийлсэн мөнгөний нэгж

Санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн байна.

Санхүүгийн тайлангийн бүтэц, бүрэлдэхүүн

Дархан сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яамны "Э-Тайлан"-д нэгтгэн бүртгэж, гаргасан байна. Тус программ нь нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, заавар, журамтай нийцсэн байна.

Төсвийн захирагчдын санхүүгийн үйл ажиллагаанд сумын төрийн сангийн мэргэжилтэн хяналт тавьж, зарлагын гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл болон зардлын зүйл анги бүрийг шалгаж, гүйлгээг баталгаажуулж байна.

Дархан сумын ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж тооцсон бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянаад дотоод хяналтыг үр нөлөөтэй гэж үнэллээ.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТАЛААР

Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан

Дархан сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд мөнгөн хөрөнгө 1,868,053.9 мянга, авлага 2,030,964.2 мянга, бараа материал 3,656,845.6 мянга, үндсэн хөрөнгө 127,903,018.1 мянга, нийт 135,459,881.8 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн өмнөх оноос 2.8 хувь буюу 3,635,468.9 мянган төгрөгөөр нэмэгджээ. Мөнгөн хөрөнгө 1,087,959.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь сумын орлого төлөвлөснөөс 1,082,874.9 мянган төгрөгөөр давсан, авлага 1,053,569.8 мянган төгрөгөөр өссөн нь өрхийн эмнэлгүүдийн ковидын гэрийн эмчилгээний болон дархлаажуулалтын санхүүжилтийн авлага үүссэнтэй холбоотой бол бараа материалын 543,874.4 мянган төгрөгийн өсөлт нь НААҮГ-т 335,795.8 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нийлүүлэгдсэн, ковид халдварт өвчинтэй холбоотойгоор өрхийн эмнэлгүүдийн эм боох материал 128,385.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Харин үндсэн хөрөнгийн өсөлтөд 31 дүгээр цэцэрлэг шинээр ашиглалтад орж 1,215,658.4 мянган төгрөгийн барилгыг бүртгэсэн, НААҮГ орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 2,942,994.3 мянган төгрөгийн тохижилт, тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслүүдийг үндсэн хөрөнгийн холбогдох дансдад бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан

ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангаар илэрхийлэгдсэн 3,596,894.6 мянган төгрөгийн тайлант хугацааны үр дүнд үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого нөлөөлжээ.

Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан

ТЕЗ-ийн 2021 оны цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайланд засгийн газрын хувь оролцоо дансны 59,840.0 мянган төгрөгийн өсөлт нь 31 дүгээр цэцэрлэг шинээр байгуулагдсан, НББ-ийн бодлогын өөрчлөлт, дахин үнэлгээний өсөлт, бууралтын 83,457.9 мянган төгрөгийн өөрчлөлт нь 12 дугаар сургууль, НААҮГ, 15 дугаар цэцэрлэг дахин үнэлгээтэй хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан

Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангаар мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,807,959.9 мянган төгрөгөөр буюу 2.4 дахин өссөн байна.

Нэгтгэсэн тайлангийн аудитын илрүүлэлт:

- Дархан сумын ЗДТГ, 30 дугаар цэцэрлэг 5,084.6 мянган төгрөгийн бараа материалыг ангилал зөрүүлэн бүртгэсэн
- ТШЗ-ийн 25 байгууллага НБББББ-т тусгаадаагүй ангиллаар 881,663.3 мянган төгрөгийн бараа материалыг бүртгэсэн.
- ХААИС-ийн лицей сургуулийн тайланг 90,007.5 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэсэн.
- Дархан сумын ЗДТГ 20,559.7 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг үндсэн үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн.
- Малын тоо толгойн албан татварын 30,950.1 мянган төгрөгийн орлогыг төсөвт тусгаагүй.
- Шилэн дансны нэгдсэн системд 3 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг байршуулаагүй.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс ангилал буруу бүртгэсэн 25,644.3 мянга, тайланг зөрүүтэй нэгтгэсэн 90,007.5 мянган төгрөгийн алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэн, шилэн дансанд мэдээлээгүй 3 мэдээг нөхөж байршуулах, хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлж, орлогыг төсөвт тусгаагүй 30,950.1 мянга, ангилал буруу 881,663.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах зөвлөмжийг өглөө.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА, АУДИТЫН ДҮН

Нэг. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл тайлант оны эхэнд 697,953.6 мянган төгрөг байснаас 11.8 хувиар өсөж, оны эцэст 780,094.0 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Мөнгөн хөрөнгийн 2020 оны үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр харуулбал:

/мян.төг-өөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
			Касст байгаа	Банкинд байгаа	
				Төрийн сангийн нэгдсэн данс	Арилжааны банк
Касст байгаа бэлэн мөнгө	0.0	0.0	0.0	0.0	0.0
Банкинд байгаа мөнгө:	780,094.0	1,868,053.9	0.0	1,844,794.1	23,259.8
Төрийн сангийн харилцах	780,069.2	1,844,794.1	0.0	1,844,794.1	0.0
Арилжааны банк	24.8	23,259.8	0.0	0.0	23,259.8
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	780,094.0	1,868,053.9	0.0	1,844,794.2	23,259.8
<i>Байгууллагын төрлөөр авч үзвэл:</i>					
Төрийн сан	780,069.2	1,598,894.1	0.0	1,598,894.1	0.0
Төсөл/сан	0.0	245,900.1	0.0	245,900.1	0.0
ОНӨААН	24.8	23,259.8	0.0	0.0	23,259.8
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	780,094.0	1,868,053.9	0.0	1,844,794.2	23,259.8

Банкин дахь харилцах дансны үлдэгдэл 1,868,053.9 мянган төгрөгийн 1,844,794.1 мянган төгрөг нь төрийн сан дахь харилцах дансанд, 23,259.8 мянган төгрөг нь арилжааны банкинд байршиж байна.

Төрийн сангийн харилцахад байгаа 1,844,794.2 мянган төгрөгийн 1,598,894.1 мянган төгрөг нь сумын ерөнхий орлогын дансны, 245,900.1 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сангийн дансны үлдэгдэл байгаа бол арилжааны банкин дахь 23,259.8 мянган төгрөг нь ХААИС-ийн харьяа лицей сургуулийн дансны үлдэгдэл байна.

Мөнгөн хөрөнгийн дансанд илэрсэн алдаа, зөрчлүүд:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар анхан шатны баримтын бүрдэл дутуу байх, дансны харьцааг алдаатай хийх зэрэг нийт 52,716.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 52,576.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан /1 дүгээр сургууль 3,660.5 мянга, 4 дүгээр сургууль 47,742.9 мянга, Гэрэлтэй өрхийн эмнэлэг 1,172.6 мянга/
- 5 дугаар цэцэрлэг 140.0 мянган төгрөгийн дансны бичилтийг буруу хийсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 47,882.9 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 4,833.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгчээ.

Хоёр. Авлага

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын эхний үлдэгдэл 977,394.4 мянган төгрөг байснаас тайлант онд 1,053,569.8 мянган төгрөгөөр өсөж, оны эцэст 2,030,964.2 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Авлагын үлдэгдлийг бүтэц, байгууллагын төрлөөр нь харуулбал:

Авлагын төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Ажиллагчидтай холбогдсон авлага	0.0	200.0	200.0
Татаас, санхүүжилтийн авлага	50,448.1	0.0	(50,448.1)
Байгууллагаас авах авлага	18,347.7	1,254,473.0	1,236,125.3
Хувь хүмүүсээс авах авлага	908,598.6	776,291.2	(132,307.4)
Дүн	977,394.4	2,030,964.2	1,053,569.8
<i>Байгууллагын төрлөөр:</i>			
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	0.0	1,224,768.7	1,224,768.7
Төсөл/сан	947,669.1	775,927.2	(171,741.9)
Төсөвт байгууллага	29,725.3	30,268.3	543.0
Дүн	977,394.4	2,030,964.2	1,053,569.8

Хүснэгтээс үзэхэд татаас, санхүүжилтийн болон хувь хүмүүсээс авах авлага 50,448.1-132,307.4 мянган төгрөгөөр буурсан байхад байгууллагаас авах авлага 1,236,125.3 мянган төгрөгөөр өсжээ.

Авлагыг төрлөөр нь авч үзвэл байгууллагаас авах авлага 61.8 хувь, хувь хүмүүсээс авах авлага 38.2 хувийг эзэлж байна.

Нийт авлагын 60.3 хувийг 5 өрхийн эмнэлгийн ковидын гэрийн эмчилгээний болон дархлаажуулалтын санхүүжилтийн авлага, 38.2 хувийг сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн авлага, 1.5 хувийг төсөвт байгууллагын авлага эзэлж байна.

Авлагын дансанд илэрсэн алдаа, зөрчлүүд:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар авлага барагдуулахад анхаарч ажиллаагүй, шийдвэргүйгээр авлага бууруулсан, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, авлагыг бүртгэлгүй орхигдуулах, илүү бүртгэх зэргээс 57,832.2 мянган төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

- Дархан сумын ЗДТГ авлагыг барагдуулахад анхаарч ажиллаагүй, мөн шийдвэргүйгээр авлага хаасан 33,064.2 мянга, авлагыг бүртгэлд тусгаагүй 16,096.0 мянган төгрөг,
- Дархан сумын СХС 6,172.0 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй,
- Гэрэлтэй өрхийн эмнэлэг 2,500.0 мянган төгрөгөөр авлагыг илүү бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 35,128.1 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 16,532.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 6,172.0 мянган төгрөгийн зөвлөмж өгчээ.

Гурав. Бараа материал

Нэгтгэсэн тайланд бараа материалын эхний үлдэгдэл 3,112,971.2 мянган төгрөг байснаас оны эцэст 3,657,845.6 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Санхүүгийн тайланд тусгагдсан дүнгээр авч үзвэл :

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Түүхий эд материал	966,305.3	1,212,148.2	245,842.9
Бэлэн бүтээгдэхүүн	14,563.3	0.0	(14,563.3)
Хангамжийн материал	2,132,102.6	2,444,697.4	312,594.8
Нөөцийн бараа	4,000.0	1,000.0	(3,000.0)
Дүн	3,116,971.2	3,657,845.6	540,874.4
<i>Байгууллагын төрлөөр:</i>			
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	355,876.9	536,520.1	180,643.2
Төсөвт байгууллага	2,761,094.3	3,121,325.5	360,231.2
Дүн	3,116,971.2	3,657,845.6	540,874.4

Бараа материалын үлдэгдлийн 14.7 хувь нь ОНӨААТҮГ, 85.3 хувь нь төсөвт байгууллагад байна.

Бараа материалын өсөлт нь НААҮГ-т 335,795.8 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нийлүүлэгдсэн, ковид халдварт өвчинтэй холбоотойгоор өрхийн эмнэлгүүдэд эм боох материал 128,385.9 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансанд илэрсэн алдаа, зөрчлүүд:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын бүртгэл, тайлагнал, тооллого, анхан шатны баримтын бүрдэлттэй холбоотой 81,195.4 мянган төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн байна. Тухайлбал:

- Бараа материалыг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардалд бичсэн 7,230.4 мянга /Дархан сумын ЗДТГ 6,629.0 мянга, 1 дүгээр сургууль 601.4 мянга/
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу 37,467.3 мянга /Дархан сумын ИТХ 2,220.0 мянга, 23 дугаар цэцэрлэг 3,170.2 мянга, 1 дүгээр сургууль 12,186.6 мянга, 15 дугаар сургууль 15,190.5 мянга, 13 дугаар цэцэрлэг 4,700.0 мянга/
- Бараа материалыг ангилал буруу бүртгэсэн 29,814.3 мянга /Гос хот өрхийн эмнэлэг 1,512.0 мянга, 25 дугаар цэцэрлэг 10,274.7 мянга, 13 дугаар цэцэрлэг 505.5 мянга, 18 дугаар цэцэрлэг 7,928.5 мянга, 8 дугаар цэцэрлэг 7,708.6 мянга, 1 дүгээр сургууль 1,885.0 мянга/
- 23 дугаар цэцэрлэг 4,375.0 мянган төгрөгийн бараа материалыг бөөн дүнгээр орлогод авсан,
- 10 дугаар цэцэрлэг, 9 дүгээр сургууль 1,852.6 мянган төгрөгийн материалын зарцуулалтыг тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 47,259.9 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 88.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 6,629.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 27,218.5 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Дөрөв. Үндсэн хөрөнгө

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 82,394,306.1 мянган төгрөг байснаас тайлант онд 44,555,647.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 126,949,953.2 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Нийт үндсэн хөрөнгийн 75.8 хувь нь төсөвт байгууллагуудад, 24.2 хувь нь ОНӨҮГ-т бүртгэлтэй байна.

Үндсэн хөрөнгийг нэр төрлөөр нь ангилбал дараах байдалтай байна:

Үндсэн хөрөнгийн нэр төрөл	/мян.төг-өөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Барилга байгууламж, орон сууц	62,628,653.7	63,521,587.4	892,933.7
Авто тээврийн хэрэгсэл	606,363.2	795,890.4	189,527.2
Машин тоног төхөөрөмж	2,527,952.3	2,873,361.5	345,409.2
Тавилга эд хогшил	1,559,560.4	1,545,614.9	(13,945.5)
Зам гүүрийн байгууламж	2,581,267.3	2,481,640.7	(99,626.6)
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	600,339.1	600,339.1	0.0
Бусад үндсэн хөрөнгө	12,203,590.1	11,771,196.3	(432,393.8)
Номын фонд	941,560.5	970,509.8	28,949.3
Программ хангамж	39,457.8	28,333.5	(11,124.3)
Бусад биет бус хөрөнгө	43,261,208.8	43,314,544.5	53,335.7
Дүн	126,949,953.2	127,903,018.1	953,064.9
<i>Байгууллагын төрлөөр:</i>			
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	1,999,339.9	2,320,046.3	320,706.4
Төсөвт байгууллага	124,950,613.3	125,582,971.8	632,358.5
Дүн	126,949,953.2	127,903,018.1	953,064.9

Үндсэн хөрөнгийн нийт үлдэгдлийн 66.1 хувийг биет хөрөнгө, 33.9 хувийг биет бус хөрөнгө эзэлж байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө өссөн нь 31 дүгээр цэцэрлэг шинээр ашиглалтад орж 1,215,658.4 мянган төгрөгийн барилгыг бүртгэсэн, НААҮГ-т орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2,942,994.3 мянган төгрөгийн тохижилт, тоног төхөөрөмж, авто тээврийн хэрэгслүүд нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансанд илэрсэн алдаа, зөрчлүүд:

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, дахин үнэлгээний нэмэгдэл аль хөрөнгөд хамаарах нь тодорхойгүй, хасах үлдэгдэлтэй илэрхийлэх, дансны бичилтийг буруу хийх, элэгдлийг зөв тооцоогүй, ангилал зөрүүлэн бүртгэсэн зэрэг үндсэн хөрөнгийн данстай холбоотой 3,502,817.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрлээ. Тухайлбал:

- Хөрөнгийг бүртгэлд тусгаагүй 2,946,300.2 мянга /НААҮГ 2,942,994.3 мянга, 5 дугаар цэцэрлэг 3,305.9 мянга/,
- Хүүхдийн номын ордны үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний 17,828.7 мянган төгрөгийн нэмэгдэл нь аль хөрөнгөд хамаарах нь тодорхойгүй,
- Хөрөнгийг хасах утгатай илэрхийлсэн 1,055.1 мянга /НААҮГ 953.3 мянга, 13 дугаар цэцэрлэг 101.8 мянга/,
- Гос хот өрхийн эмнэлэг 3,072.0 мянган төгрөгийн дансны бичилтийг буруу хийсэн,
- Элэгдлийн зардлыг зөв тооцоогүй 524,487.9 мянга /30 дугаар цэцэрлэг 2,397.7 мянга, НААҮГ 442,114.4 мянга, 1 дүгээр сургууль 79,975.8 мянга/,
- 13 дугаар цэцэрлэг үндсэн хөрөнгөд 5,300.0 мянган төгрөгийн бараа материал бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 3,483,236.4 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 19,580.9 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Тав. Өр төлбөр

Нэгтгэсэн санхүүгийн тайланд өр төлбөр дансны эхний үлдэгдэл 91,799.2 мянган төгрөг байснаас тайлант онд 1,683.2 мянган төгрөгөөр буурч, оны эцэст 90,116.0 мянган төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мян.төг-өөр/	
			Өөрчлөлт	
Төрийн сан	0.0	0.0		0.0
Орон нутгийн байгууллага	91,799.2	5,554.7	(86,244.5)	
ОНӨҮГ	0.0	64,978.8		64,978.8
Дүн	91,799.2	70,533.5	(21,265.7)	

Тайлант онд татаас, санхүүжилттэй холбоотой үүссэн 19,582.5 мянган төгрөгийн устгах бичилт хийсэн бөгөөд МЭДС ТОВ өрхийн эмнэлэгт ковидын өвчлөлийн санхүүжилт дутуу орж ирснээс 64,978.8 мянган төгрөгийн өр үүссэн байна.

Өр төлбөрийн дансанд илэрсэн алдаа, зөрчлүүд:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өр төлбөрийг бүртгээгүй, орлогоор бүртгэсэн, өмнөх онд өр төлбөр үүсгэлгүйгээр тайлант оны төсвөөс зарцуулсан зэрэг 7,173.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрлээ. Тухайлбал:

- НААҮГ 5,000.0 мянга, 6 дугаар цэцэрлэг 554.7 мянган төгрөгийн өглөгийг тайланд тусгаагүй,
- Музей 1,075.7 мянга, 4 дүгээр цэцэрлэг 237.4 мянган төгрөгийг өмнөх онд өр төлбөр үүсгэлгүйгээр тайлант оны төсвөөс зарцуулсан,
- Гэрэлтэй өрхийн эмнэлэг 305.9 мянган төгрөгийн өр төлбөрийг орлогоор бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 5,860.6 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 1,313.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Зургаа. Цэвэр хөрөнгө, өмч

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд цэвэр хөрөнгө 131,732,613.7 мянган төгрөг байснаас тайлант онд 3,656,734.6 мянган төгрөгөөр өсөж, оны эцэст 135,389,348.3 мянган төгрөгөөр тайлагнагдсан байна.

Өсөлтийн шалтгаан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Цэвэр хөрөнгө, өмчтэй холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

Долоо. Орлого, татаас санхүүжилт

а. Орон нутгийн орлого

Дархан сумын орон нутгийн төсвийн нийт орлогыг 6,348,471.0 мянган төгрөгөөр төлөвлөснийг 117.1 хувийн биелэлттэй буюу 1,082,874.9 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ.

Орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр харуулбал дараах байдалтай байна:

Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мян.төг-өөр/	
			Зөрүү	Хувь
Татварын орлого	5,655,716.9	6,597,337.4	941,620.5	116.6
Үйл ажиллагааны орлого	493,529.1	459,709.1	(33,820.0)	93.1
Хөрөнгө борлуулсны ОАТ	926,983.4	1,329,737.5	402,754.1	143.4
Хөрөнгийн орлого	2,864,264.8	3,234,056.1	369,791.3	112.9
Бусад орлого	308,239.6	401,541.5	93,301.9	130.3
Бууны албан татвар	12,000.0	15,188.0	3,188.0	126.6
Малын хөлийн татвар	0.0	30,950.1	30,950.1	-
Улсын тэмдэгтийн хураамж	50,000.0	49,761.8	(238.2)	99.5
Газрын төлбөр	408,200.0	322,326.1	(85,873.9)	79.0
Түгээмэл тархацтай АМАТ	2,500.0	8,308.9	5,808.9	332.4
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	540,000.0	712,477.6	172,477.6	131.9

Ус рашааны нөөц ашигласны төлбөр	50,000.0	33,280.7	(16,719.3)	66.6
Татварын бус орлого	692,754.1	834,008.6	141,254.5	120.4
Хүү, торгуулийн орлого	253,954.1	255,673.0	1,718.9	100.7
Төсөвт байгууллагын өөрийн орлого	23,800.0	37,570.8	13,770.8	157.9
СХС-ийн орлого	415,000.0	540,764.8	125,764.8	130.3
Нийт орлого	6,348,471.0	7,431,345.9	1,082,874.9	117.1

Сумын хэмжээнд орон нутгийн төсвийн орлого 7,431,345.9 мянган төгрөгт хүрч орлогын төлөвлөгөө 17.1 хувиар давж биелснээс татварын орлого 941,620.5 мянган төгрөгөөр, татварын бус орлого 141,254.5 мянган төгрөгөөр тус тус давсан байна.

Энэ нь хөрөнгө борлуулсны, хадгаламжийн хүүний, сум хөгжүүлэх сангийн, бусад орлогууд болон хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөвлөгөөнөөс давсан, мөн малын тоо толгойн албан татварын орлогыг төлөвлөгөөнд тусгаагүйтэй холбоотой байна.

б. Татаас, санхүүжилт

2021 онд аймгаас Дархан сумын төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 747,694.4 мянга, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 1,394,186.8 мянга, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт 31,215,748.1 мянган төгрөгөөр батлагдсан бөгөөд орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 118,908.7 мянган төгрөгөөр дутуу, бусад санхүүжилтүүд төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрчээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 91.5 хувьтай байгаа нь ажлын гүйцэтгэл дутуугаас 18,705.4 мянган төгрөгийг санхүүжүүлээгүй, гүйцэтгэгч 45,123.3 мянган төгрөгийн ажлаас татгалзсан, 55,000.0 мянган төгрөгийн 7 төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй зэргээс шалтгаалсан байна.

Орлогын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 дүгээр сургууль 980.9 мянга, НААҮГ 505.0 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг тайланд тусгаагүй байсныг аудитын явцад залруулсан байна.

Найм. Төсвийн зарлага

Дархан сумын ТЕЗ-ийн 2021 оны төсвийн нийт зарлага ба цэвэр зээлд 40,484,690.1 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 39,394,629.4 мянган төгрөг зарцуулж, зардлын гүйцэтгэл 97.3 хувьтай гарсан байна.

ТЕЗ-ийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	40,484,690.1	39,394,629.4	(1,090,060.7)	97.3
Урсгал зардал	39,012,594.1	38,322,380.3	(690,213.8)	98.2
БАҮ-ний зардал	36,753,994.0	36,081,051.7	(672,942.3)	98.2
Татаас	1,383,223.6	1,383,223.6	0.0	100.0
Урсгал шилжүүлэг	875,376.5	858,105.0	(17,271.5)	98.0
Хөрөнгийн зардал	1,072,096.0	778,849.1	(293,246.9)	72.7
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	400,000.0	293,400.0	(106,600.0)	73.4

Нийт зарлагын гүйцэтгэлийн 97.3 хувийг урсгал зардал, 2.0 хувийг хөрөнгийн зардал, 0.7 хувийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл эзэлж байна.

Урсгал зардал хэмнэгдсэн шалтгаан нь тайлант онд ковид халдварт өвчинтэй холбогдон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн үйл ажиллагаа түр хугацаанд цахимаар зохион байгуулагдсантай холбоотой байна.

Хөрөнгийн зардлыг төлөвлөгөөнөөс дутуу санхүүжүүлсэн нь орон нутгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээнээс зарим ажлын гүйцэтгэл дутуу, 10 ажил огт хийгдээгүйгээс төлөвлөгөө 72.6 хувьтай биелсэн байна.

Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл буюу СХС-ийн гүйцэтгэл олгосон зээлтэй холбоотой байна.

Зардлын данстай холбоотой гарсан зөрчлийн талаар:

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар цалинг буруу тооцоолсон, цалин, түүний нэмэгдлийг илүү олгосон, урамшууллыг давхардуулсан, цалин хөлсний зардлаас шагнал олгосон, зардлыг ангилал буруу бүртгэсэн, зардлыг дутуу тайлагнасан, тэтгэвэр тогтоолгосон ажилтанд төрийн албаны цалин олгосон, хөрөнгийн зардлаас урсгал зардлыг санхүүжүүлсэн, дутуу зэрэг 122,271.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Тухайлбал:

- Дархан сумын хөрөнгө оруулалт хөрөнгийн зардлаас 27,000.0 мянган төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлсэн,
- Дархан сумын ОНХС 1 ажлыг 2 төсөл арга хэмжээнд хуваасан 14,000.0 мянга, хийгдээгүй 5,000.0 мянган төгрөгийн ажлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрсөн,
- 23 дугаар цэцэрлэг 2,000.0 мянган төгрөгийн урсгал засварын, 1 дүгээр сургууль 3,276.0 мянган төгрөгийн хангамжийн материалын, 4 дүгээр сургууль 1,076.0 мянган төгрөгийн нормативт зардлыг тус тус дутуу тайлагнасан,
- 4 дүгээр сургууль 24,800.5 мянган төгрөгийн зардлыг ангилал зөрүүлэн бүртгэсэн,
- Цалин, хөлстэй холбоотой алдаа зөрчил нийт 40,407.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлүүдээс 39,038.0 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулга хийлгэж, 10,136.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 5,070.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 68,026.6 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

Ес. Хөрөнгө оруулалт

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 15 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр 387,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 212,661.8 мянган төгрөгийг зарцуулжээ.

Тайлант онд хэрэгжсэн 15 төсөл, арга хэмжээнээс ажлын гүйцэтгэл дутуугаас 22,193.2 мянган төгрөгийг санхүүжүүлээгүй, хил хаагдсантай холбоотойгоор 152,145.0 мянган төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Арав. Орон нутгийн хөгжлийн сан

ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрээр 2021 онд хөрөнгө оруулалт, их засварын 8 ажилд 435,861.1 мянга, иргэдийн оролцоотой 34 төсөл хөтөлбөрт 249,234.9 мянга, нийт 685,096.0 мянган төгрөгийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр сумын ИТХ-аар баталжээ.

2021 онд төсвийн нийт зарлагын гүйцэтгэл 566,187.3 мянган төрөг буюу 82.6 хувьтай байгаа нь ажлын гүйцэтгэл дутуугаас 18,705.4 мянган төгрөгийг санхүүжүүлээгүй, 80.0 мянган төгрөгийг хэмнэсэн, гүйцэтгэгч 45,123.3 мянган төгрөгийн ажил гүйцэтгэхээс татгалзсан, 55,000.0 мянган төгрөгийн 7 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй зэргээс шалтгаалжээ.

Арван нэг. Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн залруулга

Дархан сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Дархан сумын ЗДТГ 3,653.6 мянган төгрөгийн бараа материал, 20,559.7 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлогыг, 30 дугаар цэцэрлэг 1,431.0 мянган төгрөгийн бараа материалыг ангилал зөрүүлэн бүртгэсэн, ХААИС-ийн лицей сургуулийн санхүүгийн тайланг 90,007.5 мянган төгрөгөөр зөрүүтэй нэгтгэснийг аудитын явцад залрууллаа.

Арван хоёр. Дараагийн аудитаар авч үзэх асуудал

Дараагийн аудитаар анхаарал татахуйц чухал асуудал байхгүй болно.

Арван гурав. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуульд төсвийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу явуулахаас гадна хяналт тавьж ажиллахаар заасан.

Дархан сумын орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагууд Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын дагуу www.shilendans.gov.mn хуудсанд шаардлагатай мэдээллийг тавьж ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуулийн хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Дархан сумын ТЕЗ нь өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй, төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбар, төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийн 3 мэдээллийг 5 дугаар сард хугацаа хоцроож, жилийн эцсийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг мэдээлээгүйд албан шаардлага хүргүүлээ.

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитын илрүүлэлт:

Дархан сумын ТЕЗ-ийн багцад хамаарах байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 697,019.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Дархан сумын ЗДТГ 29,680.0 мянган төгрөгийн 5 зарлагын гүйлгээ, 6,247.7 мянган төгрөгийн 1 орлогын гүйлгээг мэдээлээгүй,
- Дархан сумын хөрөнгө оруулалт 10 мэдээллийг хугацаа хоцроож, 87,355.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй,
- Номын сан 6,000.0 мянган төгрөгийн 1 мэдээллийн зарцуулалтын шийдвэрийг оруулсан боловч гүйлгээг оруулаагүй,
- Дархан сумын ОНХС 9 мэдээллийг хугацаа хоцроож, 274,079.8 мянган төгрөгийн 2 мэдээллийг оруулаагүй,
- Од цогцолбор сургууль, 6 дугаар цэцэрлэг тус бүр 1 мэдээллийг, Дархан сумын ИТХ 10 мэдээллийг, НААҮГ 173,325.7 мянган төгрөгийн 20 мэдээллийг хугацаа хоцроосон,
- Түвшин холбоо өрхийн эмнэлэг 6 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг оруулаагүй,
- 27 дугаар цэцэрлэг Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3, 6.4.5, 6.4.7 дахь заалтуудыг зөрчсөн,
- 4 дүгээр сургууль 4 мэдээллийг хугацаа хоцроож, 100,273.6 мянган төгрөгийн мэдээллийг үнэн зөв оруулаагүй,
- 22 дугаар цэцэрлэг 6,500.0 мянга, 9 дүгээр сургууль 7,558.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй 6,000.0 мянган төгрөгийн мэдээллийг аудитын явцад нөхөн байршуулж, 315,527.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 375,492.8 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Дархан сумын ТЕЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 7,521,406.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 58.4 хувь буюу 4,391,738.3 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 0.1 хувь буюу 10,304.5 мянган төгрөгийн зөрчилд хохирлыг барагдуулах төлбөрийн акт тогтоож, 22.6 хувь буюу 1,699,549.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 18.9 хувь буюу 1,419,814.4 мянган төгрөгийн зөрчлийг засах, давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

Арван тав. Тайлбар мэдүүлэг

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил дутагдлын талаар асуудлын бүртгэл хөтөлж, 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр сумын Засаг даргад хүргүүлж, хариу тайлбар авч, баталгаажуулсан болно.

Арван зургаа. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Дархан сумын ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж байх 1 зөвлөмж өгсөн ба биелэлтийг 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01/1090 тоот албан бичгээр ирүүлжээ.

Тайлагналын дараах үеийн хяналт шалгалтаар зөвлөмжийг биелүүлж ажиллаагүй гэж үнэлсэн ба санхүүгийн тайлангийн аудитаар ч алдаа зөрчил дахин давтагдсанд албан шаардлага хүргүүлжээ.

Арван долоо. Зөвлөмж

Сумын Засаг дарга Т.Тулгаад:

1. 2022 оны сумын орлогын төсөвт малын тоо толгойд ногдуулсан албан татварын хэмжээг 71,340.0 мянган төгрөгөөр төлөвлөн баталсан боловч орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр болон зарцуулалтад төлөвлөөгүй байна. Иймд Төсвийн тухай хуулийн 60.2, 60.2.8 дахь заалт, ОНХС-ийн журмын 4.5,4.6 дахь заалтуудыг мөрдөж ажиллах.

2. Төсвийн шууд захирагчийн 25 байгууллага 881,663.3 мянган төгрөгийн бараа материалыг НББ-ийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй ангиллаар бүртгэсэн тул 2022 оны эхний хагас жилийн тайланд залруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Залруулаагүй 953,003.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшний 1,358,023.7 мянган төгрөгөөс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өглөө.

Арван найм. Зөрчилгүй санал дүгнэлт

Дархан сумын ТЕЗ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.МӨНХБАЯР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

С.БАТЦЭЦЭГ

